



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 1/12

Хужирт сум

Засмал болон явган хүний замын
хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх талбайн
хуваарь батлах тухай

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төв дэх засмал болон явган хүний зам, авто зогсоолын дагуух хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх аж ахуйн нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээний газруудын хуваарьт газрын хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Аж ахуй нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээний газруудыг дээрх хуваарийн дагуу шуурхай ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг “Хужирт Эрдэс баялаг” УТҮГ-ын дарга (Ж.Шижээ), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бямбасүрэн), 4, 5 дугаар багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Хавсралтанд заасан хэмжээ, зургийн дагуу цэвэрлэх ажлыг байнга тогтмолжуулан хэвшүүлж ажиллахыг худалдаа үйлчилгээний газрууд, аж ахуй нэгж, байгууллагын захирал, эрхлэгч тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ